




Гарын авлага >>>>>

ИНТЕРНЭТ БАНК


ХҮСЭЛТ ИЛГЭЭХ - ГҮЙЛГЭЭНИЙ ЭРХ ӨСГӨХ

Хүсэлт илгээх - Гүйлгээний эрх өсгөх



АЛХАМ 1

Та Egolomt.mn вэбсайт руу нэвтрэн орж зүүн хэсэгт байрлах "Хүсэлт илгээх - Хүсэлт үүсгэх" цэс рүү орно.



АЛХАМ 2

Хүсэлтийн төрөл хэсгээс "Гүйлгээний эрх өсгөх" төрлийг сонгож эрх нэмэх дүнг оруулан "Файл оруулах" товчийг дарна. Гүйлгээний эрх өсгөх тухай гар хүсэлтийг PDF болгон оруулж "Үргэлжлүүлэх" товчийг дарна.

Хүсэлт илгээх - Гүйлгээний эрх өсгөх

Хүсэлт:	Гүйлгээний эрх өсгөх
Гүйлгээний эрх нэмэх дүн:	100,000,000.00
Зориулалт:	Өндөр дүнтэй гадаад гүйлгээ хийхэд лимит хүрэхгүй байгаа тул
Утасны дугаар:	990000000
Илгээсэн файлууд:	9124712.png

Buttons: Буцах, Үргэлжлүүлэх

АЛХАМ 3

Хүсэлтийн мэдээллийг шалган "Үргэлжлүүлэх" товчийг дарна.



8.3. Интернет банкны хэрэглэгч нь хуулийн этгээд бол интернет банкны үйлчилгээ хэрэглэгч ажилтнуудынхаа санаатай болон санамсаргүй үйлдлээр интернет банкны үйлчилгээтэй хийсэн бүхий л үйлдлийн үр дүнг бүрэн хариуцах ба үүнээс үүдэн банк болон гуравдагч талд аливаа хохирол учирвал холбогдох талуудын өмнө бүрэн хариуцна.

8.4. Интернет банкны хэрэглэгч нь иргэн бол интернет банкны үйлчилгээтэй холбоотой санаатай болон санамсаргүй үйлдлээр хийсэн бүхий л үйлдлийн үр дүнг бүрэн хариуцах ба үүнээс үүдэн банк болон гуравдагч талд аливаа хохирол учирвал холбогдох талуудын өмнө бүрэн хариуцна.

8.5. Харилцагч нь энэхүү гэрээ болон хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Банкинд учирсан хохирлыг үл маргах журмаар, бүрэн хариуцан арилгах үүрэгтэй.

8.6. Онцгой нөхцөл байдал дууссанаар харилцагч иргэн, хуулийн этгээд нь банкны салбарт биечлэн хандаж интернет банкны үйлчилгээ үзүүлэх журмын дагуу банкнаас шаардсан бүрдүүлэх материалуудыг цаасаар нөхөж бүрдүүлж өгөх үүрэгтэй.

Ес. Хэрэглэгч солигдох

9.1. Харилцагч нь хуулийн этгээд бол түүний хүсэлтээр интернет банкны үйлчилгээнд хэрэглэгч нэмэх эсхүл хэрэглэгчийн төлөвийг идэвхгүй болгоно.

9.2. Харилцагч нь хэрэглэгч нэмэх эсхүл хэрэглэгчийн төлөвийг идэвхгүй болгох тохиолдолд төлөөлөх эрх бүхий ажилтан нь өөрийн иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспорттай мөн тухайн дансанд 1-р гарын үсэг зурах эрх бүхий ажилтны гарын үсэг, тамга бүхий албан бичигтэй Банкинд хандана.

Арав. Давагдашгүй хүчин зүйл

10.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас /дайн, байлдаан, үймээн самуун болох, гал түймэр гарах, газар хөдлөх, үер болох зэрэг урьдаас төлөөлөх боломжгүй тохиолдлууд/ интернет банкны үйлчилгээг үзүүлэх боломжгүй болсон тохиолдолд үйлчилгээг түр зогсоож болох бөгөөд ийнхүү үйлчилгээг түр зогсоосноос учирсан хохирлыг Банк хариуцахгүй.

10.2 Харилцагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан Банк гэрээнд заасан үүргээ биелүүлж чадаагүй бол энэ гэрээнд заасан үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Арван нэг. Бусад

11.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талууд харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар эсхүл гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.

11.2. "Тусгай эрхтэй Интернет банкны үйлчилгээний санамж" /Хавсралт 1/, гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт, харилцагчид олгосон гарын авлага, Банкны цахим хуудсаар мэдээлэгдсэн "Ерөнхий нөхцөл", төлбөр тооцооны цагийн хуваарь, заавар, хүсэлт, сонголтууд болон бусад мэдээллүүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг мөн.

11.3. Банк нь тухайлсан харилцагчийн нууцад үл хамаарах, интернет банкны үйлчилгээний нөхцөл, зохицуулалт зэрэг нийтэд хамаарах мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулсан нь уг мэдээллийг харилцагчид хүргүүлсэнд тооцогдоно.

11.4. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй асуудал нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана.

11.5. Гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

Үйлчилгээний гэрээ / нөхцөлтэй танилцаж зөвшөөрсөн болно

Батлах нууц үг

Мартсан ?

Батлах нууц үг

Баталгаажуулах

АЛХАМ 4

Үйлчилгээний гэрээ/ нөхцөлтэй танилцан, зөвшөөрч буй сонголтыг дарж Батлах нууц үгээ оруулан "Үргэлжлүүлэх" товчийг дарснаар таны хүсэлт амжилттай илгээгдэнэ.

Танд амжилт хүсье.